

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР  
ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ /2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС/**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
<b>ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>							
1	4.2.1. Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.	1. Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.	2021 - 2024	-	Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Их сургуулийн авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх 2022 оны ажлын төлөвлөгөөний дагуу дараах ажил, арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: - ХАСХОМ мэдүүлэх үүрэг бүхий албан тушаалтнуудаас баталгаажуулалтын хуудас хүлээн авах хуваарийн дагуу 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийг дуустал 131 баталгааны маягт хүлээн авч, ХАСХОМ бүрдүүлсэн байдалд хяналт тавин баталгаажуулж, тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн. - Их сургуулийн захирлын 2021 оны А/02 дугаартай тушаалаар “ХАСХОМ мэдүүлэхэд анхаарах асуудал” сэдэвт сургалтыг 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр ХАСХОМ мэдүүлэх үүрэг бүхий 129 албан хаагчийг хамруулан цахимаар зохион байгуулсан. - Ажлын байр шилжихтэй холбоотой 78 албан хаагчийн урьдчилсан мэдүүлгийг нээн хянаж, 25 албан бичгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, ашиг сонирхлын зөрчил үүсээгүй тухай хариуг хүлээн авч, албан тушаалтнаас ажлын байранд томилогдсон 45 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг хянан бүртгэсэн. - Их сургуулийн цахим хуудсанд авлигатай холбоотой шторкийг бэлтгэн байршуулж, хууль сахиулах байгууллагын алба хаагчийн давтан мэргэшүүлэх сургалтын болон эрх зүйч бэлтгэх сургалтын хөтөлбөрт Авлигын гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх мэдлэг боловсролыг	100

						дээшлүүлэх чиглэлийн сургалтыг 120 багц цагт багтаан агуулгын хувьд тусгах ажлыг зохион байгуулсан.	
2	4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	2021 - 2024	-	Сургалт, сурталчилгааг явуулснаар үнэт зүйл, үндсэн зарчмаа хэрэгжүүлж, манлайллыг хангаснаар ёс зүйн зөрчил буурна.	Их сургуулийн захирлын 2022 оны А/234 дүгээр тушаалаар “Дотоод хэргийн их сургуулийн багш, албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм”, “Дотоод хэргийн их сургуулийн багш, албан хаагч, ажилтны сахилгын дүрэм”, “Дотоод хэргийн их сургуулийн суралцагчийн сахилгын дүрэм”-ийг тус тус баталсан.  Их сургуульд 2022 онд шинээр томилогдсон 103 албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй, үнэт зүйлийн талаар сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулж, бүрэлдэхүүн сургуулийн 3000 гаруй суралцагчдад Их сургуулийн шинэчилсэн "Сахилга, ёс зүйн дүрэм"-ийг танилцуулан, ёс зүйн сургалтыг зохион байгуулж, баталгаа гаргуулан авсан.  Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 180 дугаар зарлигаар цэргийн нийтлэг дүрмүүдийг шинэчлэн баталсан. Үүнтэй холбогдуулан Дотоод хэргийн их сургуулийн Цэргийн зохион байгуулалт, хангалт үйлчилгээний газраас нийт бие бүрэлдэхүүнд шинэ дүрмүүдийг таниулах, цэргийн хэргийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, 500 гаруй албан хаагч, ажилтанг хамруулсан.  Тайлангийн хугацаанд Их сургуулийн 18 багш, албан хаагч, 7 сонсогчид холбогдох 14 удаагийн зөрчилд албаны шалгалт явуулж, холбогдох хууль, дүрэм, журмуудыг зөрчсөн үйлдлүүдэд нь хариуцлага тооцон, 13 багш, албан хаагч, 3 сонсогчид сахилгын шийтгэл ногдуулсан байна.	100

3	<p>4.3.2. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.</p>	<p>8. Дотоод хэргийн их сургуулийн шинжлэх ухаан, инновацын чадавхыг хотхон хэлбэрээр хөгжих замаар нэмэгдүүлж, сургалтын үйл ажиллагаанд олон улсын чанарын удирдлагын ISO-9001:2015 стандартыг нэвтрүүлнэ.</p>	2021 - 2024	28.6 сая төгрөг	<p>Их сургуулийн хотхонд албаны тусгай бэлтгэлийн сургалтын инновацыг нэвтрүүлж, магистрын сургалтын 3 хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлсэн байна. Олон улсын чанарын удирдлагын ISO-9001:2015 стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.</p>	<p>2021 онд Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагаанд олон улсын ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоо, ISO 21001:2018 боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлсэн. Энэхүү олон улсын стандартын стандарт хэрхэн хэрэгжиж байгааг үнэлж дүгнэх, нэгдсэн менежментийн тогтолцооны хэрэгжилт, явц, сайжруулалтыг үнэлэх магадлах аудитыг Олон улсын баталгаажуулалтын эрхтэй “Монсертф” компаниар 2022 оны 10 дугаар сарын 19-нөөс 21-ний өдрүүдэд хийлгүүлж, гэрчилгээг 1 жилийн хугацаатай сунгуулаад байна.</p> <p>“Гамшиг судлал”, “Хил судлал”, “Хууль сахиулах удирдлага” магистрын сургалтын хөтөлбөрийг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлүүлж, гэрчилгээ авсан.</p> <p>Түүнчлэн Их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх ажлын хүрээнд актлах шаардлагатай барилгуудад хамаарах дүгнэлтийг гаргуулсны үндсэн дээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ирсэн шийдвэрт үндэслэн Их сургуулийн данс бүртгэлээс хөрөнгийг хасуулах ажлыг зохион байгуулж байна. Актлах барилгын сууринд баригдах барилгуудын техник эдийн засгийн үндэслэлийг гаргуулж, зураг төслийн ажлыг хийж гүйцэтгүүлэх ажлын явц 80-90%-тай байна.</p> <p>Их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан спорт, албаны сургалтын байгууламжийн ажлыг эхлүүлэх, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг Их сургуулийн захирлын 2022 оны А/524 дүгээр тушаалаар байгуулж, ажлын хэсгийн хурлыг зохион байгуулан ажилласан.</p>	100
---	---	--	-------------	-----------------	--	--	-----

4	<p>4.3.2. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.</p>	<p>9. Дотоод хэргийн их сургуулийн бүтэц зохион байгуулалтыг салбарын хөгжилтэй уялдуулан алба хаагчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлж үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор шат дараатай арга хэмжээ авна.</p>	2020 - 2024	500.5 сая төгрөг	<p>"Спорт цогцолбор, номын сан"-гийн байрны хүчин чадлыг бүрэн ашиглаж, мэргэшсэн боловсон хүчинтэй болгоно. Ажлын ачааллын тэнцвэржилт 20 хувьд хүрсэн байна.</p>	<p>Их сургуулийн "Спорт цогцолбор-Номын сан"-ийн барилга ашиглалтад шаардлагатай орон тоог нэмэгдүүлэх саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсний дагуу тус яамны дэмжлэгтэйгээр 2022 оны төсвийн байр ашиглалтын зардалд уг санхүүжилт батлагдсан.</p> <p>Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан төрийн албан хаагчийн цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлэх ажлын хүрээнд Их сургуулийн албан хаагч, ажилтны цалинг нэмэгдүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх шаардлагатай судалгааг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Дотоод хэргийн их сургуулийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглээр санал болон хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар хэрэгжүүлэх чиг үүрэг, ажил үйлчилгээний мэдээллийг тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p>	100
5	<p>4.4.3. Хуульчийн мэргэжлийн шалгалт, үргэлжилсэн сургалт, хууль зүйн чиглэлийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх, хуульчдын мэргэжлийн</p>	<p>2. Эрх зүйч, хууль сахиулагч бэлтгэхэд дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах тухайлсан хуулийн төслийг боловсруулж, Улсын Их хуралд өргөн мэдүүлнэ.</p>	2020- 2024		<p>Хуулийн төслийг боловсруулсан байна.</p>	<p>Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хянаж, дахин хэлэлцүүлэхээр ирүүлсний дагуу 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдөр албан хаагч, ажилтны хүрээнд дахин нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, дүнг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өгсөн чиглэлийн дагуу тус яаманд дээр байгуулагдсан ажлын хэсгээс төсөлд бусад яамдуудаас санал авах ажлыг зохион байгуулж байна.</p>	100

өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлж, эдийн засаг, бизнесийн эрх зүйгээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэнэ.						
--	--	--	--	--	--	--

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ